

## НИИГАТА МУЖ, ЗҮҮН ХОЙТ АЗИ, ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА

Б. Балдоо

1995 оны хоёрдугаар сард «Зүүн хойт Азийн эдийн засгийн форум» байгууллагын ээлжит 5-р уулзалт болж түүнд Япон, БНСУ, БНАСАУ, БНХАУ, ОХУ, Монгол, АНУ болон НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр зэрэг олон улсын байгууллагын төлөөлөгчид оролцсон юм. Япон улс түүний Ниигата муж уг уулзалтыг өөртөө зохиох санаачилга гарган Ниигата хотод хийлгэн эзэн улс, эзэн хот болсон юм. Уулзалтыг бэлтгэн явуулах бүх ажилд Ниигатын «Зүүн хойт Азийн эдийн засгийн судалгааны хүрээлэн» (ЕРИНА) хүчин зүтгэл гарган идэвхтэй оролцсон юм.

Энэ өгүүлэл-танилцуулгад «ЗХА-ийн эдийн засгийн форум» байгууллагын 5-р уулзалт болж өнгөрсөн Ниигата мужийн тухай, Ниигатын «ЗХА-ийн эдийн засгийн судалгааны хүрээлэнгийн» талаар товч өгүүлье.

**Ниигата муж ба Зүүн хойт Ази.** Ниигата муж (префектур) нь Япон улсын гол арал Хонсюгийн дундад хэсэгт Япон тэнгисийн эрэгт оршино. Ниигата муж 2480 гаруй мянган хүн амтай (1993 он) бөгөөд Япондоо 14-рт ордог. 12 мянга гаруй хавтгай дөрвөлжин километр газар нутагтай бөгөөд Японы нутгийн 3.3 хувийг эзлэн, 47 мужийн дотор 5-рт ордог. Мужид 20 том, 56 жижиг хот, 37 тосгон байдаг.

Мужийн нийслэл хот нь Ниигата, хагас сая хүн амтай. Тус хот японы өрнөд эргийн соёл, улс төр, эдийн засгийн төв бөгөөд Токигоос 300 км, Осакагаас 500 км зайд, Өмнөд Солонгосын Пусан, Умард Солонгосын Чонжин, Оросын Владивосток, Находка зэрэг хотуудаас барагцаалбал 1000 км радиуст оршино.

Ниигатын усан боомт Японы анхны олон улсын таван боомтын нэг юм. Евроази тив болон Хятад, Солонгос, Орос улсуудын өөдөөс харсан ганц боомт бөгөөд эдгээр улстай харилцах усан замын харилцаа энэ боомтоор дамжин явагддаг. Ниигатад Японы өрнөд эргийн агаарын харилцааны гол буудал байдаг. 70-аад оноос Орос, Солонгос, Хятадтай агаарын нислэгийн харилцаа тогтоосон ажээ. Ниигата хот Токиотой төмөр зам түүний дотор хурдан галт тэрэгний шугамаар холбогджээ.

Дэлхийн хоёрдугаар дайны дараагаас аж үйлдвэржиж эхэлсэн энэ мужид нэхмэл, металл, хими гэх зэрэг аж үйлдвэрийн олон төрлийн салбар хөгжиж их хэмжээний орчин үеийн эрэлт хэрэгцээтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргадаг. Энэ мужид дэлхий дээр хамгийн сайн цагаан будааны нэг төрлийг тариалдаг бөгөөд энд ой, загасны аж ахуй сайн хөгжжээ.

Ниигата муж баялаг түүхтэй, түүхийн ба соёлын үнэт өв сантай. 1993 оны мэдээгээр үндэсний ба мужийн Засгийн газрын ивгээлд авсан 450 гаруй соёлын үнэт өв бүртгэгджээ. Түүхийн өв уламжлалыг хадгалан арвижуулах, орчин үеийн соёл, урлаг, боловсрол, шинжлэх ухааныг хөгжүүлэх талаар

\* Б. Балдоо. — ЗХАСТ-ийн тэргүүлэх ажилтан, академич

тус муж ихээхэн амжилт олжээ. Ниигата мужийн байгаль үзэмжтэй сайхан, агаар улирал нь зөөлөн, өвөл, зуны спорт хөгжүүлэх, тойрон аялагчдыг цэнгүүлэх өргөн бололцоотой ажээ.

Олон улсын харилцаа өргөжиж буй өнөө үед Япон улсаас айл зэргэлдээ орнуудтайгаа соёл, технологи болон эдийн засгийн хэлхээ холбоог хөгжүүлэхэд Ниигата мужийн үүрэг оролцоо улам өсч байна. Ниигата нь түүхийн туршид Хятад, Монгол, Солонгос ба Оросын Алс Дорнодтой хэлхээ холбоотой байсан учир эдүүгээ Япон далайн эрэг хавийн солилцсоны үйл ажиллагааг өрнүүлэхэд нэгэн чухал түшиг тулгуур нутаг болох зорилт тавигдаж байгаа ажээ. Ниигата дурдсан хөрш улс үндэстэнтэй харилцааг гүнзгийрүүлэхийн хамтад бас Зүүн Өмнөд Ази, АНУ, Европтой харилцааг хөгжүүлэхэд санаачилга гарган ажиллаж буй.

Ниигата муж гадаад харилцааг өрнүүлж байгаа зарим баримтыг жишээ болгон дурьдвал: Ниигата муж БНХАУ-ын Хар мөрөн мужтай 1993 онд албан ёсны найрамдлын хэлэлцээр байгуулжээ. Тэр хэлэлцээрийн үндсэн дээр Хар мөрөн мужаас оюутан авч өөрийн сургуулиудад сургах, залуучуудыг харилцан солилцох, хөдөө аж ахуй болон технологийн бусад салбарт хамтран ажиллах явдлыг хэрэгжүүлж байна. Орос улстай сүүлийн хэдэн жил солилцоо, ялангуяа эдийн засаг, хүн солилцоог эрчимтэй өрнүүлж байна. Энэ солилцоо нь Ниигатад ба Оросын Алс Дорнодод худалдааны үзэсгэлэн гаргах, бизнесийн ба эдийн засгийн төлөөлөгчид харилцан илгээх, орон нутгийн захиргааны гишүүдийг солилцох хэлбэрээр хэрэгжих болсон байна. Владивостокийг нээлттэй хот болгох ёслолд Ниигата мужийн төлөөлөгчид оролцож Японы цайны ба цэцгийн ёслол, фото зургийн үзэсгэлэн, мод суулгах ёслол, хоёр талын дээд сургуулиудын бөхийн чөлөөт барилдаан гэх зэрэг арга хэмжээнд оролцох замаар Ниигата-Оросын харилцааг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулжээ. Ниигата Өмнөд Солонгостой хэлхээ холбоог өргөтгөхөд анхаарч ирсэн байна. Ниигата муж нь Сеул хотод өөрийн албан газартай болсон японы орон нутгийн цөөн засгийн газрын нэг бөгөөд Сеул хүртэл агаарын харилцааны үйлчилгээ хийдэг болжээ.

Ниигата нь тойрон аялалыг хөгжүүлэхдээ эдгээр хөрш орноос олон аялагчид авах явдлыг нэн чухалд үздэг ажээ. Ниигата мужийн олон хот, тосгоны захиргаанд найрамдалт харилцааг хөгжүүлэхэд бусад улсын хотуудтай ах дүүсэг харилцааг тогтоох явдал чухал болохыг ойлгон 1993 оны 11-р сард мужийн 13 том жижиг хот, тосгоны захиргаа 11 орны хотууд, тэдгээрийн дотор Орос, Хятадын хотуудтай албан ёсны ах дүүсэг хотын харилцаа тогтоосон байна. Энэ нь тэдгээр хот тосгодын хооронд хүмүүсийг харилцан айлчлуулах, мэдээлэл солилцоход чухал үүрэг гүйцэтгэж байна. Бас нэг тэмдэглүүштэй үйл явдал бол 1992 оны 10-р сард Ниигатын олон улсын ассоциацийг (НОУА) байгуулсан явдал юм. Энэ нь олон улсын идэвхтэй солилцоонд татагдан орсон хувь хүмүүс, бүлгүүдийн үйл ажиллагааг хооронд нь зохицуулан зохион байгуулах төв байгууллага болсон байна. Ассоциац нь солилцооны төслүүдийг

хэрэгжүүлэхэд төлөвлөгөө ба санхүүгийн туслалцаа үзүүлдэг байна. Ассоциац нь Япон, Англи, Хятад хэл дээр хэвлэдэг «NIA NEWS» (НОУА-ийн мэдээ) хэмээх сэтгүүл гаргадгийн дээр олон хэл мэддэг сайн дурынхныхтай болсон бөгөөд тэд нь гадаадаас ирсэн бочдод мэдээлэл олж өгөх, зөвлөлгөө өгөх зэргээр үйлчилдэг болсон байна.

- Ниигата хотын Зүүн хойт Азийн эдийн засгийн судалгааны хүрээлэн (ЕРИНА). Ниигата муж 90-ээд оны эхээр гадаад харилцааг өрнүүлэх талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааны нэг чухал илэрхийлэл нь 1993 оны 10 дугаар сарын 1-нд Япон улсын Олон улсын худалдаа ба аж үйлдвэрийн яамны зөвшөөрлийн үндсэн дээр «Зүүн хойт Азийн эдийн засгийн судалгааны хүрээлэн ЕРИНА»-г байгуулсан явдал юм. Тус хүрээлэн нь 3 тэрбум 325 сая иений үндсэн хөрөнгөтэйгээр, «Ерөнхий төлөвлөлтийн хэлтэс», «Эрдэм шинжилгээний хэлтэс» гэсэн хоёр үндсэн нэгжтэйгээр байгуулагджээ. Түүний удирдах болон зөвлөх байгууллагын бүрэлдүүнд Японы эдийн засгийн олон төрлийн эрдэм шинжилгээний болон аж ахуй, бизнесийн байгууллагын төлөөлөгчид оролцож байдаг ажээ.

Тус хүрээлэн байгуулагдах хэрэгцээ шаардлагын талаар Ниигата мужийн захирагч Икуо Нираяма бичихдээ: «Зүүн хойт Азийн бүс нутаг нь хэрэг дээрээ өргөн олны анхаарлыг өөртөө ихээхэн татах болсон бөгөөд түүний ирээдүйн хөгжил, солилцооны өргөжилт нь ХХI зууны төрх төлөвийн зүйл мөн. Зүүн хойт Азийн бүс нутгаар мэргэжсэн эдийн засгийн судалгааны хүрээлэн болж байгаагийн нь хувьд ЕРИНА-гаас бүс нутгийн улс орнууд болон Япон улс их зүйлийг хүлээж байна... ЕРИНА энэхүү бүс нутгийн эдийн засгийн харилцан солилцоо, хөгжлийг урагш ахиулахад үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна» гэсэн юм.

Тус хүрээлэн нь түүний ерөнхийлөгч Хисао Канамрийн бичсэнээр, Зүүн хойт Азийн эдийн засгийн талаар өргөн судалгаа явуулах, мэдээллийг цуглуулан түгээх, семинар симпозиум зохиох зэрэг үндсэн үүрэгтэй байгуулагджээ. ЕРИНА-ийн ерөнхийлөгч Х. Канамори: — Зүүн хойт Азийн бүс нутагт Япон тэнгисийг хүрээлэн буй зургаан орон ба бүс нутаг, өөрөөр хэлбэл Япон, Оросын Алс дорнод, Хятадын Зүүн хойт хэсэг, БНСУ, БНАСАУ болон Монгол хамаарна; — Энэ нутаг дэвсгэр нь Зүүн өмнөд Азитай харьцуулбал хөгжлөөр сул; гэвч бүс нутагт хамаарах улс орон тус бүрт буй янз бүрийн хүч чадлыг нэгтгэн нийлүүлж чадвал ЗХА нь хөгжлийн хүчирхэг потенциалтай нутаг дэвсгэр болно; —одоогоор энэ бүс нутгийн талаар явуулах судалгаа, мэдээллийн аль алиг нь хангалтгүй байна; —тэгэхлээр ЕРИНА суурь судалгааг явуулах, шинэ соргог, мэдээллийг цуглуулан түгээх ажлын аль алиныг гүйцэтгэх ёстой гэж үзэж байна.

Дээр дурдсантай холбогдон ЕРИНА-г байгуулсан гол зорилтууд тодорхойлогдсон байна. Үүнд:

Зүүн хойт Азийн бүс нутгийн орнууд нь харилцан бие биеийг нөхөж үйлдвэрлэлийг хөгжүүлэх олон хүчин зүйлтэй бөгөөд тэдгээр нь үндсэндээ байгалийн ихээхэн баялаг, үлэмж хэмжээний ажиллах хүч хүчний нөөц, өндөр технологи болон хөрөнгө оруулах их хэмжээний сан зэргээс бүрдэх юм. Хэрэв

бүс нутагт багтан орж байгаа улс орон болон дэглэмүүд Зүүн хойт Азийн эдийн засгийг буй болгохын төлөө хамтран ажиллаж чадвал хөгжил дэвшлийг хангахуйц үлэмж их потенциалтай гэдэг итгэлийг төрүүлж байгаа юм. Гэвч тэдгээр орон, дэглэмүүдэд одоо байгаа зах зээлийн эдийн засгийн төвшин, эдийн засгийн хөгжилдээ туулж буй үе шат, дэд бүтэц болон эдийн засгийн системийг бүрэлдүүлэн буй болгох бололцоо зэргээр тэдгээр нь хоорондоо ялгаатай учраас энэ бүс нутагт нэгдсэн аж ахуйг байгуулахад нэлээд урт хугацаа шаардагдана.

Ийм нөхцөлд Зүүн хойт Азийн орнууд өөрсдийн дэд бүтцийг хүчтэй болгох, оршин байгаа эдийн засгийн дэглэмийг зах зээлийн эдийн засаг болгон хувиргах зайлшгүй чухал мэдлэгээр дутагдаж буй учраас ийм мэдлэгээр зэвсэглэх талаар Япон улстай хамтран ажиллах явдлаа эрчимжүүлэхийг эрмэлзэх болжээ. Япон улс өөрийн эдийн засгийн түргэн хөгжлийн ачаар олон улсын талбарт нэн чухал байр суурь эзлэх болсон цагаас хойш Зүүн хойт Азийн эдийн засгийг үүсгэн буй болгож хөгжүүлэх талаар үлэмж ач холбогдолтой үүргийг гүйцэтгэх болсон нь нийтэд тодорхой болсон билээ.

ЕРИНА-г үндэслэн байгуулахдаа дараах зүйлийг анхааран үзсэн байна. Япон улсад баялаг сэтгэлгээний сан (THINK TANKS) бүрэлдэн тогтоод тэр нь өөрийн чухал хувь нэмрийг улсынхаа хөгжилд оруулж байгаа юм. Тэгэвч Зүүн хойт Азийн эдийн засгийг судлахад ямар нэгэн нэмэгдэл хүчин чармайлт гаргах хэрэгцээ шаардлага бий болсон гэдгийг япончууд ойлгон мэдрэх болжээ. Энд асуудлын гол нь Зүүн хойт Азийн талаар тусгайлан бодож боловсруулан, хэрэгжүүлж биелүүлэх сэтгэлгээний санг (THINK—AND—DO TANK) буй болгох нь зайлшгүй чухал гэж үзсэн байна. Энэ сан нь Зүүн хойт Азийн бүс нутгийн эдийн засаг болон эдийн засгийн солилцооны талаар тус нэмэр хүргэхуйц мэдээллийг цуглуулан түгээх, энэ бүс нутгийг хөгжүүлэхэд оруулах хувь нэмрийг арвижуулах хүчин чармайлтыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн бодлого үйлдэхэд нэн хэрэгтэй зөвлөмжүүдийг боловсруулах зорилготой эдийн засгийн судалгааг байнга явуулахад анхаарлаа төвлөрүүлэх юм. Энэ үзэл санааг удирдлага болгон Ниигатад Зүүн хойт Азийн эдийн засгийн судалгааны хүрээлэнг байгуулахаар шийдвэрлэсэн ажээ.

Энэ хүрээлэнгийн гол үйл ажиллагаа юунд чиглэгдэж байна вэ?

ЕРИНА нь: ЗХА-ийн бүс нутгийн улсуудын тухай мэдээллийг аж үйлдвэрийн, академи судалгааны засгийн газрын байгууллагууд болон өргөн олон нийтэд зориулан цуглуулан түгээх.

Энэ бүс нутгийн нэгдсэн эдийн засгийг бүрэлдүүлэн хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор тус хүрээлэн нь ЗХА-ийн өнөөгийн эдийн засгийн байдлыг задлан шинжлэх, бүс нутгийг хөгжүүлэх бололцоо нөхцөлийг танин мэдэх, мөн түүнчлэн ЗХА-ийн эдийн засгийн (ЗХАЭЗ) тухай шинжилгээ судалгаа, тоймчилсон танилцуулга бэлтгэх зэрэг ажлыг эдийн засгийн бусад хүрээлэнгүүдтэй хамтран хийх.

Бизнесийн үйл ажиллагааг тустай мэдээллээр хангах, хамаарах бүс нутгуудын дотор эдийн засгийн солилцоог өрнүүлэх.

Симпозиум, семинар зохиох замаар захиргааны академик

судалгааны болон бизнесийн байгууллагуудын дунд мэдээлэл ийгээд санал солилцоход үйлчлэх, ЗХАЭЗ-ийг хөгжүүлэх эрмэлзлэл санаачлагыг төрүүлэн гаргах, энэхүү зорилгоор бүсийн улс орнуудаас улс төрийн бодлогоо үйлдэхэд нь хэрэгтэй санал зөвлөмжүүд гаргах зорилго тавьж байгаа ажээ.

Зүүн хойт Азийн эдийн засгийн судалгааны хүрээлэнгийн судалгааны үндсэн чиглэл ба зохиож буй симпозиум, семинарын тойм, ЕРИНА нь өөрийн өмнө дэвшүүлэн тавьсан зорилгуудыг биелүүлэх үүднээс гадаад, дотоодын эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллах чиглэлийг тогтоон, ЗХА-ийн эдийн засгийн талаар чанарын өндөр түвшинд судалгаа явуулдаг буюу явуулах эрмэлзлэл бүхий эрдэм шинжилгээний байгууллагуудыг хамтран ажиллах аргаар уриалж байгаа ажээ. Урьд нь гадаад орны, тухайлбал Оросын ШУА-ийн Эдийн засгийн хүрээлэн, Зах зээлийн прогнозын олон улсын хүрээлэн зэрэгтэй хамтран ажиллаж байсан туршлагатай юм байна. ЕРИНА байгуулагдсанаас хойш ОХУ-ын ШУА-ийн эрдэм шинжилгээний байгууллагууд, БНХАУ-ын Төрийн зөвлөлийн дэргэдэх болон Зүүн хойт Хятадын гурван муж дахь эдийн засгийн эрдэм шинжилгээний байгууллагууд, Өмнөд Солонгосын судалгааны байгууллага зэрэг 10 гаруй эрдэм шинжилгээний байгууллагатай холбоо тогтоон хамтын ажиллагааг явуулдаг болжээ. Тэдгээртэй Япон тэнгисийн талаар мэдээлэл солилцон, бүс нутгийн талаар хамтарсан судалгаа явуулах болж хүн солилцоог хэрэгжүүлж эхэлжээ. Энэхүү хамтын ажиллагаанд тулгуурлан ЗХА-ийн мэдээллийн сан байгуулах зорилт тавьж байгаа юм байна. Үүний хамт гадаад дотоодын байгууллагууд хүсвэл өөрт хуримтлагдсан мэдээллээс тэдгээрт өгдөг байна.

Гадаад орны эдийн засгийг судалдаг Японы дотоод дахь эрдэм шинжилгээний байгууллагууд, их дээд сургуулиудтай ЕРИНА холбоо тогтоон, хамтын ажиллагааг өрнүүлэн явуулж байна. Хүйтэн дайн дуусвар болсны дараагаар Японы аж үйлдвэрийн газрууд гадаадын үйлдвэр аж ахуйн газруудтай хамтран ажиллах сонирхол өссөнийг харгалзан энэ чиглэлд өөрийн үйл ажиллагааг ЕРИНА чиглүүлж байна. ЕРИНА Засгийн газрын шугамаар гадаадынханд үзүүлж байгаа эдийн засгийн тусламжийн асуудал, ОДА-г судлахад анхаарлаа төвлөрүүлж ийм судалгааг бусад байгууллагатай хамтран явуулах болжээ.

ЕРИНА өөрийн үйл ажиллагааны эхний жилүүдэд судалгааны дараах чиглэлийг тодорхойлсон байна. Үүнд:

— Зүүн хойт Азийн хөгжлийн хэтийн төлөв (Түмэн голын сав газрыг хөгжүүлэх төслүүдийг хэрэгжүүлэх асуудлын агуулга ба хэлбэрийн талаархи судалгаа)

— Эдийн засгийн хөгжил ба аж үйлдвэрийн бүтцийн өөрчлөлт (ЗХА-ийн эдийн засгийг хөгжүүлэхэд аж үйлдвэрийн үүрэг, энэ талаар Японоос үзүүлж буй тусламжийн асуудлаархи судалгаа)

— ЗХА-ийн хөгжлийн төслүүд (бүс нутагт хамаарч буй улсуудад боловсруулан хэрэгжүүлж байгаа төслөөс өргөн бөгөөд бүс нутгийг бүхэлд нь хамарсан судалгаа буюу суурь судалгаанаас эхлээд төслийг хэрэгжүүлэх арга техник хүртлэх асуудлын судалгаа)

— Тэнгисийн эрэг орчмын бүс нутгийн дэд бүтэц (зам тээвэр, холбоо харилцаа, эрчим хүч зэрэг салбаруудын судалгаа, Үүнийг Орос, Хятадын байгууллагуудтай хамтран явуулж буй. Энэ судалгаа нь тус бүс нутгийн дэд бүтцийн хөгжилд оруулах хөрөнгө оруулалтын талаар лавламж гаргахад ач холбогдолтой болох аж)

— ОХУ-ын тэнгисийн эрэг хавийн мужуудтай явуулах худалдааны харилцаа (энэ судалгааны үндсэн дээр худалдааны бодлого боловсруулах байгууллагуудад зөвлөмж бэлтгэж өгнө. Анх түрүүчийн зөвлөмжүүдийг Ниигата муж хүлээн аваад хэрэгжүүлж эхэлсэн байна).

— Япон тэнгисийн орнуудын харилцаа (Японоос Солонгос, Хятадтай худалдаа арилжааг өргөтгөх, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэхэд хэрэгтэй судалгаа. Ихээхэн материал цугларсан бөгөөд энэ нь худалдаа, аж үйлдвэрийнхэнд чухал хэрэгцээтэй болж буй).

— Ниигата мужийн эдийн засагт бараа солилцооны ач холбогдлын тухай судалгаа.

— Оросын аж үйлдвэрийн газруудын өнөөгийн байдал, ирээдүйн төлөвийн судалгаа.

— ОХУ зах зээлийн эдийн засагт шилжих үеийн Орос Японы харилцаа (энэ нь хоёр орны харилцаат мужууд, ялангуяа Хабаровск, Приморийн хязгаартай явуулах хамтын ажиллагааны чанарыг дээшлүүлэх, Орос, Японы эдийн засгийн хамтын ажиллагааны орчин бүрэлдүүлэхэд үлгэр жишээч судалгаа болно гэж судалгааны чиглэлийг боловсруулагчид үзэж байгаа ажээ).

— ЗХА-ийн ашигт малтмалын газрын зургийг гаргах (энэ зураг нь ЗХА-ийг, түүний дотор Оросын Алс Дорнодыг хөгжүүлэхэд нэн чухал гарын авлага болохоор тооцогдож байгаа аж).

— Эх газрын зам тээвэр ба холбоо харилцааны газрын зураг (энэ зураг хийгдсэнээр эх газар дахь дэд бүтцийг хөгжүүлэх урьдчилсан нөхцөлийн нэгийг бүрдүүлэх болно гэж үзэж байна).

Эдгээр судалгааны чиглэл нь 1995 оны эхний байдлаар тодорхойлогдож байгааг тэмдэглэе.

Энэхүү танилцуулах материалын төгсгөлд ЕРИНА-гаас 1993—1994 онд зохиосон семинар, симпозиумын тухай товч дурдъя. Семинар, симпозиумыг ЕРИНА өөрөө бие даан зохиохын хамт Японы ба гадаад орны холбогдох байгууллагуудтай хамтран, 1993 оны эцсээс зохиож ирэхдээ судалгааны дээр дурдсан чиглэлийн хүрээнд хэрэгжүүлж байсан байна. Заримыг нэрлэвэл:

— Зүүн хойт Азийг хөгжүүлэхийн төлөө (анхны семинар); ЗХА дахь эдийн засгийн хөгжил ба аж үйлдвэрийн бүтэц (симпозиум); ЗХА дахь эдийн засгийн хамтын ажиллагааны одоогийн байдал ба цаашдын төлөв (симпозиум); Японы аж үйлдвэр Хятад, АСЕАН-ы орнуудад нэвтэрч байгаа асуудал (семинар); Оросын Алс Дорнодын эдийн засгийн хөгжил, аж үйлдвэрийн салбар дахь хамтын ажиллагааны арга хэлбэр (Япон, НҮБ, Оросын хамтарсан симпозиум); Япон, Оросын аж үйлдвэрийн газруудын хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудал (бага

хурал); Оросын Зарубино усан боомтыг хөгжүүлж, түүнтэй Япон тэнгисээр дамжуулан шууд харилцаа тогтоох асуудал (ажлын семинар); Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагаа; бүс нутгийн хөгжлийн ач холбогдол, ирээдүйн төлөв ба ЗХА дахь эдийн засгийн хамтын ажиллагаа (ЗХА-ийн эдийн засгийн форум (ЗХА ЭЗФ)-ын 5-р уулзалт, ЗХАЭЗФ байгууллагатай хамтран) гэх зэрэг олон семинар, симпозиумыг зохиосон байна.

Ниигатын Зүүн хойт Азийн эдийн засгийн судалгааны хүрээлэн (ЕРИНА) нь «ERINA REPORT» (ЕРИНА-ийн мэдээлэл) хэмээх сэтгүүл нийтэлдэг бөгөөд түүнд ЗХА-ийн бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн асуудлаарх судалгааны өгүүлэл, танилцуулга, мэдээ зэргийг хэвлэхийн хамт хүрээлэнгээс зохиож буй судалгааны ажлын талаар өргөн сурталчилдаг байна.

Энэ лавлагааг ЕРИНА танилцуулга, ЕРИНА-г мэдээлэл (1995, №5)-ийн материалд үндэслэн бэлтгэв.